ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан[1])

ТӨЛӨӨЛӨГЧ НЬ ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРХ ХЭМЖЭЭГ ХЭТРҮҮЛЭН, ТӨЛӨӨЛӨХ ЭРХГҮЙГЭЭР ЭД ХӨРӨНГИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛСНЭЭС ТӨЛӨӨЛҮҮЛЭГЧИД УЧИРСАН ГЭМ ХОРЫГ ХАРИУЦАН АРИЛГАХ ҮҮРЭГТЭЙ

САНАМЖ: *Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.*

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2026/00169

Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 06 сарын 15 өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч Б.Б нь 2024.01.19-ний өдөр “...Зээл олгоно гэсэн зарын дагуу Г.А-тэй холбогдоход “Б.Д-д итгэмжлэл олгож, нотариатчаар батлуулаад барьцаалах тээврийн хэрэгслээ өгөөд явуулчих, данс руу чинь 6,000,000 төгрөг шилжүүлье” гэсний дагуу хариуцагч Б.Д-д итгэмжлэл олгож, тээврийн хэрэгслээ өгч явуулсан. Гэтэл хариуцагч Б.Д нь нэхэмжлэгчийн өмчлөлийн тээврийн хэрэгслийг бусдад худалдан борлуулж, итгэмжлэгчийн ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулсан...” хэмээн нэхэмжлэгч Б.Б-ээс хариуцагч Б.Д-д олгосон итгэмжлэлийг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгож, тээврийн хэрэгслийн үнэ 33,000,000 төгрөг гаргуулах шаардлага гаргасан.

Хариуцагч Б.Д нь нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрөх үндэслэлээ“... нэхэмжлэгч нь манай хамаатны ах Г.А-ээс зээл авч, барьцаанд нь *** улсын дугаартай Hummer H2 маркийн автомашин барьцаалсан. Г.А нь өөр газар байсан Г.А-д автомашиныг шилжүүлж өгөх зорилготой итгэмжлэлийг надад олгосон. Итгэмжлэлийн хугацаа дуусах гээд байсан учир Г.А нь Б.Д-д автомашиныг Э.М-д шилжүүл гэсний дагуу түүнд шилжүүлээд, буцаагаад Б.Д өөрийн нэр дээр шилжүүлсэн. Уг тээврийн хэрэгслийг Б.Д өөр рүүгээ болон Г.А рүү шилжүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байсан. Нэхэмжлэгч нь зээлээ төлж чадахгүй, улмаар тухайн автомашинаар зээлийг хаахаар тохиролцсон учир өөрт олгогдсон итгэмжлэлийн дагуу Э.М гэх хүнд шилжүүлж, түүнээс буцаан шилжүүлэн авсан. Нэхэмжлэгчийн шаардаад байгаа автомашины мөнгийг хариуцагч аваагүй учраас нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй” хэмээн маргажээ.

---

[1] Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/11126?id=3&court_cat=1

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүх** нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэхдээ: "...2024.01.19-ний өдөр нэхэмжлэгчээс хариуцагчид олгосон итгэмжлэлийг Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1[2] дэх хэсэгт заасан итгэмжлэл гэж үзнэ. Харин итгэмжлэлийн хүрээнд нэхэмжлэгч нь бодитоор тухайн тээврийн хэрэгслийг бусдад худалдан борлуулах, арилжих, гэрээ байгуулах, гэрээнд төлөөлөн гарын үсэг зурах эрх үүргийг хариуцагчид олгох зорилгогүй зөвхөн тээврийн хэрэгслийг фидуцийн нөгөө тал болох гуравдагч этгээд Г.А-ийн өмчлөлд хүлээлгэж өгөх зорилготой байсан бөгөөд үүнийг нь хариуцагч тухайн үед мэдэж байсан буюу Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2[3]-т заасан "дүр үзүүлэн хийсэн хэлцэл" гэж үзэх үндэслэлтэй байна. (8)[4]
2. Хариуцагч нь 2024.07.03-ны өдөр уг тээврийн хэрэгслийг 18,000,000 төгрөгөөр худалдах-худалдан авах гэрээг О.Д гэх иргэнтэй байгуулж, Г.А-ийн дансанд 2024.07.03-ны өдөр "машин худалдан авалт" гэх утгаар 18,000,000 төгрөгийн орлогын гүйлгээ хийгдсэн байгаагаас үзэхэд хариуцагчийн "... Г.А эргээд Б.Д-д наад машинаа энэ хүнд шилжүүл гэдэг үүрэг даалгаврыг өгсөн, нэхэмжлэгчийн шаардаад байгаа автомашины мөнгийг аваагүй..." гэх тайлбар үндэслэлтэй. Иймд нэхэмжлэгчээс хариуцагчид олгосон 2024.01.19-ний өдрийн 0116 дугаартай итгэмжлэлийг хүчин төгөлдөр бус хэлцэл болохыг тогтоож, харин нэхэмжлэгч нь хариуцагчаас тухайн тээврийн хэрэгслийн үнийг шаардах эрхгүй тул нэхэмжлэлийн шаардлагын 33,000,000 төгрөг гаргуулах хэсгийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй" гэж дүгнэжээ. (8)
3. **Давж заалдах шатны шүүх** анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэхдээ: шүүх нэхэмжлэгч, гуравдагч этгээдийн хооронд зээлийн гэрээний харилцаа үүссэн гэж энэ хэрэгт хамааралгүй асуудлаар эрх зүйн дүгнэлт өгсөн нь буруугаас гадна мөн талуудын хооронд Иргэний хуулийн 235 дугаар зүйлд зааснаар фидуцийн гэрээ бичгээр байгуулагдаагүй байхад уг гэрээ байгуулагдсан гэж дүгнэн, нэхэмжлэгчийг тээврийн хэрэгслийн үнийг шаардах эрхгүй гэж үзсэн нь хуульд нийцээгүй. Зохигчийн хооронд тээврийн хэрэгслийг бусдад чөлөөтэй захиран зарцуулахтай холбоотой харилцаа, үүрэг үүсээгүй, ийм эрхийг нэхэмжлэгч Б.Б олгоогүй байхад хариуцагч Б.Д тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлсний үр дагаврыг Иргэний хуулийн 63 дугаар зүйлийн 63.4[5]-т заасны дагуу хариуцан арилгах үүрэгтэй байна. (9)
4. Hummer H2 маркийн тээврийн хэрэгсэл 5 хүнд дамжин өмчлөх эрх шилжсэн байх тул уг тээврийн хэрэгслийг бодитоор гаргуулах боломжгүй ба нэхэмжлэгч энэ үндэслэлээр тээврийн хэрэгслийн үнийг хариуцагчаас мөнгөн хэлбэрээр гаргуулахаар шаардсан нь үндэслэлтэй. Тээврийн хэрэгсэл нь тодорхой цаг хугацаа өнгөрөхөд үнэ цэнэ нь өсдөг бус урвуу хамааралтай эд хөрөнгө учир

---

[2] Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1-д "*Төлөөлүүлэгч нь төлөөлөгч болон түүнтэй хэлцэл хийх гуравдагч этгээдэд төлөөлүүлэх тухайгаа болон төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдсэнээр төлөөлөгчид бүрэн эрх олгож болно*".

[3] Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2-т "*дүр үзүүлэн хийсэн хэлцэл*".

[4] "Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр" хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

[5] Иргэний хуулийн 63 дүгээр зүйлийн 63.4-т "*Энэ хуулийн 63.3-т заасан үүргээ биелүүлээгүйгээс төлөөлүүлэгчид учирсан гэм хорыг төлөөлөгч хариуцан арилгах үүрэгтэй*".

хариуцагч тээврийн хэрэгслийг 2024.03.19-ний өдөр бусдад шилжүүлэх үед тээврийн хэрэгслийн бодит үнэ нэхэмжлэгчийн тодорхойлсон хэмжээнд байсан гэж дүгнэхгүй, тухайн үеийн зах зээлийн үнэ ямар байсныг талууд шүүхэд гаргаагүй ба 2024.07.03-ны өдөр тээврийн хэрэгслийг 18,000,000 төгрөгөөр худалдсан тухай баримт хэрэгт авагдсаныг тухайн зах зээлийн үнэ гэж үзлээ. Иймд зохигчийн хооронд маргааны зүйл болсон тээврийн хэрэгслийг захиран зарцуулахтай холбоотой үүрэг үүсээгүй, нэхэмжлэгч тээврийн хэрэгслийг биет байдлаар буцаан шаардах боломжгүй болсон үндэслэлээр үнийг шаардсан, Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1[6]-д заасны дагуу хариуцагч Б.Д-ээс 18,000,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгоно.” гэж шийдвэрлэжээ. (9)

5. **Хяналтын шатны шүүх** давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэхдээ: Иргэний хуулийн Долдугаар бүлгээр төлөөллийн эрх зүйн харилцааг зохицуулсан ба төлөөллийн гол зорилго нь төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болох ёстой байдаг. Түүнчлэн төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх бөгөөд энэ үүргээ зөрчсөнөөс төлөөлүүлэгчид учирсан гэм хорыг хариуцан арилгах үүргийг хүлээдэг. (13)
6. Давж заалдах шатны шүүх хэрэгт цугларсан нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлж, зохигчдын хооронд үүссэн эрх зүйн харилцааг зөв тодорхойлсон бөгөөд Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасны дагуу хариуцагч Б.Д-ээс 18,000,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн магадлалын үндэслэлийг Иргэний хуулийн 63 дугаар зүйлийн 63.2[7]-т нийцсэн гэж үзэж хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ. (13)

---o0o---

[6] Иргэний хуулийн 492 дүгээр зүйлийн 492.1.1-т “*хөрөнгө олж авсан этгээд болон үүрэг гүйцэтгэгч этгээдийн хооронд үүрэг үүсээгүй, эсхүл үүрэг нь хожим дуусгавар болсон буюу хүчин төгөлдөр бус болсон*”.

[7] Иргэний хуулийн 63 дүгээр зүйлийн 63.2-т “*Төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болно*”.